

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА



**УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2021 ОНЫ 2/5107 ДУГААРТАЙ  
ЧИГЛЭЛИЙН ДАГУУ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2021.08.31

Орхон аймаг

Д/д	Үүрэг даалгавар	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах албан тушаалтан
1	Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасан хугацаанд хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргаж, тухай албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх мөн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллахад анхаарах	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх	-Хэлтсийн дарга, -Хяналтын улсын байцаагч -хэлтсийн албан хаагчид
2	Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг зохих журмын дагуу авах, бүртгэх, хянан шалгах	Албан хаагчдаас хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг зохих журмын дагуу авах, бүртгэх, хянан шалгах	-Хэлтсийн дарга

3	Албан бүрэн эрх, албан үүргээ хэрэгжүүлэх явцад учирч болзошгүй эрсдэл, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх /	-Хэлтсийн дарга, -тасгийн дарга нар
4	Албан хаагч, ажилтнуудын ажлын ачаалал, хуваарийг тэнцвэржүүлэх, албаны бүрэн эрх, албан үүргээ хэрэгжүүлэх явцад учирч болзошгүй эрсдэл, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээ		
5	Нийтийн албан тушаалтны авлигыг үл тэвчих, ес зүйтэй байх, шударга ёсыг эрхэмлэн ажиллах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг дэмжин сурталчилгааны материалыг цахим хуудас болон мэдээллийн самбар, дотоод сүлжээнд байршуулах, сурталчлах	Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг сайжруулах	Хяналтын улсын байцаагч, -Мэдээлэл технологийн ажилтан, - хэлтсийн албан хаагчид
6	Олон нийтэд зориулсан сурталчилгаа, соён гэгээрүүлэх материалыг байгууллагын болон харьяа нэгжийн цахим, пэйж хуудсаар сурталчлах		
7	Нийтийн албан тушаалтны ёс зүйн зөрчил, зүй бус үйлдэл, хуулиар тогтоосон хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн тухай мэдээлэл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авах нөхцөлийг бүрдүүлж, мэдээллийг нэгжийн мэдээллийн самбар, цахим хуудаст байршуулах		

8	Иргэдийн гомдол мэдээллийг цахим шуудан, иргэд хүлээж авах уулзалтын цаг, мэдээллийн самбарт байрлуулсан санал хүсэлтийн хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр гэх мэт олон сувгаар хүлээн авах, шалгаж шийдвэрлэж, хариу хүргүүлэх, удирдлагад танилцуулах		-Бичиг хэргийн ажилтан, -Мэдээллийн технологийн ажилтан
9	Ёс зүйн зөрчилтэй холбоотой бичгээр ирүүлсэн өргөдөл, гомдолд тавигдах шаардлага хангасан гомдол мэдээллийг байгууллагын Ёс зүйн зөвлөлд шилжүүлэн шалгуулах	ёс зүйн зөрчилтэй холбоотой бичгээр ирүүлсэн гомдол мэдээллийг хүлээн авах нөхцлийг бүрдүүлэх, бүртгэл хөтлөн байгууллагын Ёс зүйн зөвлөлд шилжүүлэн шалгуулах	-Хэлтсийн дарга, -Бичиг хэргийн ажилтан
10	Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг бүх албан хаагчид танилцуулах, хэрэгжүүлэх, үйлчилгээний танхим, мэдээллийн самбарт байршуулах	Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийг бүх албан хаагчид танилцуулан, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	-Тасгийн дарга нар, -Мэдээлэл технологийн ажилтан

11	Ажлын сахилга, хариуцлагыг бүх шатанд анхаарах, нэгжийн даргаас албан хаагч, ажилтнуудын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулж, хууль тогтоомжийг мөрдөх, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, шаардлагыг хангаж ажиллахыг анхааруулах	Хэлтсийн албан хаагч, ажилтнуудын ажлын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах	-Хэлтсийн дарга, -Тасгийн дарга нар
12	Шинээр томилогдсон албан хаагчид байгууллагын үйл ажиллагаа, хөдөлмөрийн дотоод журам, үйлчилгээний стандарт, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийг сурталчлан таниулах сургалтыг ажлын байранд хийх	Шинээр томилогдсон албан хаагчдад холбогдох хууль тогтоомжийг сурталчлан таниулах сургалтыг ажлын байранд зохион байгуулах	-Тасгийн дарга нар
13	Нэгжийн удирдлагаас байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, үйлчилгээний стандарт зөрчсөн, сануулах хуудас, анхааруулга хүлээн авсан албан хаагч, ажилтан бүрийг тухай бүр дотоод сургалтад хамруулах	Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, үйлчилгээний стандарт зөрчсөн, сануулах хуудас, анхааруулга хүлээн авсан албан хаагч, ажилтан бүрийг тухай бүр дотоод сургалтад хамруулах ажлыг зохион байгуулах	-Хэлтсийн дарга
13	Нэгжийн удирдлагаас байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, үйлчилгээний стандарт зөрчсөн, сануулах хуудас, анхааруулга хүлээн авсан албан хаагч, ажилтан бүрийг тухай бүр дотоод сургалтад хамруулах		Хэлтсийн дарга